*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# САНХҮҮ БҮРТГЭЛ, ХАМРАЛТ, ОРЛОГЫН ХЭЛТСИЙН ХАМРАЛТ, ОРЛОГО ШИМТГЭЛИЙН ӨР ХАРИУЦСАН БАЙЦААГЧ ТӨМӨРХУЯГЫН ТҮВШИНБААТАРЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.1** "НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ, ТАЙЛАН ХҮЛЭЭН АВАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | 1.1.1 Ажил олгочийн нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын хуульд заасан хугацаанд төлүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах; | Орлогын төлөвлөгөөний хувь | | | Хагас жилийн байдлаар сумдын хэмжээнд нийгмийн даатгалын шимтгэлд төлөхөөр байгуулсан 7,872.3 сая төгрөг байна. Байгуулсан шимтгэлд төлөгдөх 7,786.1 сая төгрөгийн орлогыг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 98.9 хувь биелүүлсэн байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 98.9% |
| 2. | 1.1.2 Цахим хэлбэрээр ирүүлсэн ажил олгогчийн шимтгэл төлөлтийн (НД-7; НД-8) тайланг тайланг цаасан тайлантай тулган баталгаажуулах, даатгуулагчийн мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэх, | Тайлан хүлээн авалтын хувь | 357 | 326 | Хагас жилээр сумдын 379 ажил олгогч байгууллага бүртгэлтэйгээс 326 ажил олгогчтой тооцоо нийлж 7,786.1 сая төгрөгийн шимтгэлийн ногдуулалт хийгдэж тайланг 86.0 хувийн биелэлттэй сар бүр хуулийн хугацаанд батлагдсан маягтын дагуу баталгаажуулан хүлээн авч ажилласан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн шинэ систем **portal.ndaatgal.mn** дээр гар буй | 2025.01.01<br>2025.06.30 | 86.0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өөрчлөлтүүдийн талаар мөн шинээр бүргэгдэж байгаа ажил олгогч нарт ажилтан бүртгэх, ажилтны мэдээлэл өөрчлөх, шимтгэлийн тайлан шивэх, шалгах, илгээх зэрэг бүх заавар зөвлөгөөг биечлэн өгч ажиллсан байна. | | |
| 3. | 1.1.3 Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр хүлээн авах ажлыг эрчимжүүлэх, | Тоон гарын үсгээр тайлан илгээж буй ажил олгогчийн тоо | | | 2025 онд нийгмийн даатгалын шинэ систем дээр тоон тайлан авах боломж бүрдэж эхэлсэн гэвч манай аймагт өйл ажиллагаа эрхлэн явуулдаг МОНПАСС компаний тайланг ашиглах боломжгүй байгаа юм. | 2025.01.01 2025.06.30 | 0% |
| 4. | 1.1.4 Шимтгэлийг хуулийн хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах | Улсын байцаагчийн акт, албан шаардлага хүргүүлэх, алданги тооцох, торгох шийтгэл ногдуулах, ажил олгогчийн банкин дах харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох, шүүхэд шилжүүлэх | | | Хагас жилээр Улсын байцаагчийн акт үйлдээгүй ба 102.7 сая төгрөгийн өр үүсгэсэн 4 ажил олгогчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүллээ. Мөн 171 ажил олгогчийн харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоож 56 байгууллагын 410.2 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тус тус төлүүлэн ажилласан байна.<br>Өмнөх онд шүүхийн захирамж гарсан 47.4 сая төгрөгийг төлөөгүй байсан 5 байгууллагыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэн ажиллалаа.<br>Энэ онд шимтгэлийн хуримтлагдсан өр үүсгэсэн 25 байгууллагыг Сум дундын анхан шатны шүүхэд холбогдох баримт материалыг хавсарган нэхэмжлэл хүргүүлсэн байна. | 2025.01.01 2025.06.30 | 100% |
| 5. | 1.1.5 Зөрчлийн хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаа явуулах, шийдвэрлэх | Шийдвэрлэл-тийн хувь | | Үүссэн зөрчлийн хэргийн тоогоор | Дорнод аймагт эмийн сангийн үйл ажиллагаа явуулдаг "Бур эм тан" ХХК-аас ирүүлсэн бичгийг шалгаж тус байгууллагад Зөрчлийн тухай хуулийн | 2025.01.01 2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 10 дугаар зүйлийн 10.17.4 заасан зөрчлийг хянан шийдвэрлэж тус байгууллагад 250.0 мянган төгрөгөөр торгож шийдвэрлэсэн байна. | | |
| **Зорилт 1.2.** "НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | 1.2.1 Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | Шинээр хамрагдсан ажил олгогч, даатгуулагчдын тоо | | 40 ажил олгогч, 198 даатгуулагч | Хагас жилээр аймгийн сумдын хэмжээнд 326 ажил олгогчтой тооцоо нийлж ажилласан байна. Эдгээр байгууллагуудад нийгмийн даатгалын тухай хуулийн өөрчлөлт, түүнийг дагаж мөрдөх журам түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээг ашиглан даатгуулагч иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.<br>Энэ онд шинээр бүртгүүлэхээр албан хүсэлтээ ирүүлсэн 23 ажил олгогчийн холбогдох баримт бичгийн үндэслэн хувийн хэрэг нээж, бүртгэл үүсгэсэн багууллагуудад ажиллагсдын тоо 24, даатгуулагчдыг мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн баазад бүртгэн ажиллалаа.<br>Ажил олгогч 57,5%<br>Албан журмын даатгуулагч 12,1% | 2025.01.01<br>2025.06.30 | 57,5% |
| 2. | 1.2.2 Татварын төлөгчөөр бүртгүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гарган НД-ын шимтгэл төлөгч байгууллагаар бүртгэх ажлыг зохион байгуулах | Судалгаа, зохион байгуулалтын арга хэмжээ | | | Энэ онд татварын хэлтэсээс судалгаа аваагүй өмнөх онд авсан судалдгааг хамрагдалтыг нэмэгдүүлэх ажилд ашиглаж байна. Тус газраас нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлээгүй, аж ахуйн нэгж, байгууллагаар бүртгүүлсэн татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг гаргуулан авч шинээр хамаруулах ажлыг зохион байгуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Татварын газарт бүртгэлтэй аж ахуй нэгжийн нягтлан бодогч, захирал нартай утсаар холбогдон мэдээлэл зөвлөгөө өгч, утсаар холбогдох боломжгүй аж ахуй нэгжийн үйл ажиллагаа явуулдаг ажлын байран дээр очиж мэдээлэл хүргэсэн. | | |
| **Зорилт 1.3.** "НИЙГМИЙН ДӨӨТГӨЛЫН ШИМТГЭЛИЙН ӨР, АВЛАГА БУУРУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | 1.3.1 **Нийгмийн даатгалын** сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 30-аас доошгүй хувиар бууруулах | Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн жилд бүрэн барагдуулсан байх | 1883.1 сая | 100 хувь | 2024 оны жилийн эцсээр нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлага үүсгэсэн 258 аж ахуйн нэгж байгууллагын 1,883.1 сая төгрөг байснаас 200 аж ахуйн нэгж байгууллагын 761.3 сая төгрөгийг барагдуулсан байна. Өмнөх оны өртэй 58 байгууллагын 1,121.7 сая төгрөг үлдэж барагдуулалт 40.4 хувьтай байна.<br>Хийгдсэн ажлууд,<br>• 8 аж ахуйн нэгжид 126.0 сая төгрөгийн төлбөр төлүүлэх мэдэгдэх хуудас,<br>• 102.7 сая төгрөгийг өр үүсгэсэн 4 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлсэн,<br>• 2,372.1 сая төгрөгийн өр үүсгэсэн 171 аж ахуйн нэгж байгууллагын банкан дахь харилцах дансны зарлагын гүйлгээг зогсоож,<br>• 227.2 сая төгрөгийн өр үүсгэсэн 6 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ,<br>• 789.9 сая төгрөгийн шимтгэлийн өр үүсгэсэн 25 аж ахуйн нэгж байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлэн ажилласан байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 40.4% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | 1.3.2 Төсөвт байгууллагуудын авлагыг барагдуулах, өр үүсгэхгүй байх, | Авлагын хэмжээ | 83.2 сая | 100 хувь | Төсөвт байгууллагын өр авлаггүй гаргах талаар анхааран ажиллаж байна. Энэ арга хэмжээгээр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү албанд 67 байгууллагын 852.9 сая төгрөгийн, Дорнод аймгийн боловсрол шинжлэх ухааны газарт 36 байгууллагын 321.9 сая төгрөгийн, Дорнод аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэст 7 байгууллагын 334.9 сая төгрөгийн тус тус авлагыг барагдуулах талаар албан тоот явуулж төсвийн байгууллагуудыг хагас жилээр өргүй гаргахаар чиглэн ажиллалаа. | 2025.01.01<br>2025.06.30 | 0% |
| 3. | 1.3.3 Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын өр авлагыг бууруулах, | Авлагын хэмжээ | 1,799.9 сая | 899.9 сая | Тус аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын баталсан “Авлага барагдуулах даатгуулагчийг дэмжих жил” болгон зарласан. Энэ зарласан жилээр үүссэн авлагыг барагдуулах, орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>Уг авлага барагдуулах ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтын дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй аж ахуйн нэгжүүдийг өрийг насжилтаар ангилан ажилласан. Үүнд:<br>• 8 аж ахуйн нэгжид 126.0 сая төгрөгийн төлбөр төлүүлэх мэдэгдэх | 2025.01.01<br>2025.06.30 | 40,4% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуудас өгч 118.0 сая төгрөгийг төлүүлсэн,<br>• 102.7 сая төгрөгийг өр үүсгэсэн 4 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлсэн,<br>• 2,372.1 сая төгрөгийн өр үүсгэсэн 171 аж ахуйн нэгж байгууллагын банкан дахь харилцах дансны зарлагын гүйлгээг зогсоож 56 байгууллагын 410.2 сая төгрөгийг,<br>• 227.2 сая төгрөгийн өр үүсгэсэн 6 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж 4 аж ахуйн нэгжийн 84.4 сая төгрөгийг,<br>• 789.9 сая төгрөгийн шимтгэлийн өр үүсгэсэн 25 аж ахуйн нэгж байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлэн 8 байгууллагын шүүхийн захирамжыг гаргуулан 7.6 сая төгрөгийг тус тус барагдуулан ажилласан байна.<br>Энэ ажлыг хэрэгжүүлэн ажилласнаар нийт 620.2 сая төгрөгийг төлүүлж ажилласан байна.<br>Үйл ажиллагаа нь зогссон, хаяг тодорхойгүй, эзэн холбогдогч нь сураггүй "Шинэ-интернэшнл" ХХК-ний захирал Д.Батзолбоог шүүхийн шүүгчийн захирамжаар эрэн сурвалжлуулаад байна. Энэ байгууллага нь 9.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгээд сураггүй болсон. | | |
| 4. | 1.3.4 Шимтгэлийн авлагатай байгуулагуудад "Нийгмийн даатгалын | Хуримтлагдсан авлага үүсэхээс урьдчилан | | 3,940.3 сая төг | Нийгмийн даатгалын шимтгэлийн шинэ систем нэвтрүүлсэнтэй холбоотой | 2025.01.01<br>2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 6 дахь заалтын дагуу шат дараалсан арга хэмжээ авах, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, | сэргийлж орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлсэн байна. | | | авлага насжилтаар зөв ангилж гараагүй байна.<br>2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дугаар тулаашаар баталсан "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 6 дугаар хэсэгт шимтгэлийн өр баргадуулах гэж заасан байна.<br>Авлагын насжилтыг хагас жилийн байдлаар НДЕГ-аас ирүүлсэн 3,940.3 сая төгрөгийн авлагатай гарсан.. Үүнд:<br>30 хоног 1,937.0 сая<br>31-90 хоног 763.6 сая<br>91-180 хоног 258.3 сая<br>181-270 хоног 206.6 сая<br>271-1 жил хүртэл 211.4 сая<br>1-2 жил хүртэл 294.2 сая<br>2-3 жил хүртэл 75.0 сая<br>3-4 жил хүртэл 55.4 мөнгө<br>4-5 жил хүртэл 56.3 мянга<br>5 дээш жил 81.9 сая төгрөгийн насжилттай байна.<br>Шимтгэлийн өр авлагатай холбоотой насжилтаар ангилан авлага барагдуулах журмын дагуу ажиллагааг хийж гүйцэтгэж байна. Уг ажиллагааг явуулах хүндрэлтэй байгаа асуудлуудад эзэн холбогдогч олдохгүй, утсаа авахгүй, харилцах дансанд үлдэгдэл байхгүй (захирал хувийн дансаараа ажил гүйлгээгээ хийх), гэрээ байгуулахгүй, шүүхэд шилжүүлэхэд материал бүрдүүлбэр болон шүүхийн хугацаанд буцах, хэргийг хэрэгсэхгүй болох, эрэн сурвалжлах зэргээс | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалтгаалан авлага барагдуулалт удаашралтай байна. | | |
| 5. | 1.3.5 Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй үйл ажиллагаа нь зогссон, хариуцах эзэн сураггүй болсон, хаяг тодорхойгүй аж ахуй нэгжүүдийг тодруулах, | Авлагын хэмжээ | | | Нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгээд байгаа үйл ажиллагаа нь зогссон, хаяг тодорхойгүй, эзэн холбогдогч нь сураггүй 1 хуулийн этгээдийг эрэн сурвалжлуулах шүүх хуралд миний бие хариуцагчаар оролцож шийдвэрээ гаргууллаа. Энэ байгууллага нь 2024 оны 8 дугаар сарын байдлаар 9.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн ба 2024 онд эвлэрүүлэн 2025 оны эхээр шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлсэн ч хариуцагч эзэн холбогдогч тодорхойгүй байсны учраас хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байдаг. | 2025.01.01<br>2025.06.30 | 100% |
| 6. | 1.3.6 Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай холбоотой мэдээ, тайлан. судалгаа гаргах, | Мэдээ, тайлан, судалгааг хугацаанд нь хүргүүлсэн байдал | | 100 хувь | Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд нь холбогдох албан тушаалтанд заасан хүргүүлэн ажиллалаа. | 2025.01.01<br>2025.06.30 | 100% |
| 7. | 1.3.7 Төсвийн байгууллагын авлагыг барагдуулахаар аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллах | Зохион байгуулсан арга хэмжээ | 83.2 сая | 100 хувь | Төсөвт байгууллагын өр авлаггүй гаргах талаар анхааран ажиллаж байна. Энэ арга хэмжээгээр Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү албанд 67 байгууллагын 852.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар албан тоот явуулж төсвийн байгууллагуудыг хагас жилээр өргүй гаргахаар чиглэн ажиллалаа. Мөн өмнөх онд нэг сонгуулийн хэсгийн хорооны 761.0 мянган төгрөгийг барагдуулах талаар аймгийн төрийн сангийн хэлтэстэй харилцан тохироцож | 2025.01.01<br>2025.06.30 | 99% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэмэлт сонгуулийн ажлаар тус өрийг барагдуулахаар боллоо. | | |
| 8. | 1.3.8 Шүүхийн байгууллагад Нийгмийн даатгалын хуримтлагдсан авлага барагдуулах талаар холбогдох баримт материалыг хавсарган нэхэмжлэл хүргүүлэх, | Авлага буурсан байна | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 164.6 сая | 7.1 хувь | Хагас жилийн байдлаар авлагын насжил хэтэрсэн 25 аж ахуйн нэгж байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна. Үүнд:<br>• 9 байгууллагын 598.9 сая төгрөгийн өрийг шүүхэд нэхэмжилсэн<br>• 42.5 сая төгрөгийн шимтгэлийн өр үүсгэсэн шүүхийн шүүгчийн захирамжаар төлөгдөөгүй байгаа 5 байгууллагыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраар албадан гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулахаар,<br>• 9.0 сая төгрөгийн шимтгэлийн өртэй нэг байгууллагыг эрэн сурвалжлуулахаар,<br>• 191.0 сая төгрөгийн шимтгэлийн өр үүсгэсэн 15 байгууллагыг Дорнод аймгийн сум дундын анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлахад тус тус шилжүүлээд байна.<br>Энэ ажлаар 8 байгууллагын шүүхийн шүүгчийн захирамжийг хүлээн авч авлага барагдуулахаар ажиллаж байна.<br>2024 оны жилийн эцсээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 7 байгууллагыг 164.6 сая төгрөгийг өр төлбөр төлөгдөөгүй байсан. Энэ оны эхний хагас жил бид шүүхийншүүгчийн захирамжаар төлөгдөөгүй байгаа 31.9 сая төгрөгийн өр төлбөртэй 3 | 2025.01.01<br>2025.06.30 | 99% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагыш Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт нэмж шилжүүлээд байна. Гүйцэтгэх ажиллагаагаар 3 байгуулллагын 13.4 сая төгрөгийн өр барагдуулаад байна.<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаар гүйцэтгэх ажиллагаа явуулахад удаашралтай байна. Удааширч байгаа талаар шийдвэр гүйцэтгэгч нартай уулзахад<br>-ААН-үүд өөр дээрээ хөрөнгө байдагүй<br>-ААН-үүд нь өөрийн хөрөнгийг шилжүүлсэн байдал. Өөрөөр хэлбэл: Ах дүү хамаатан сандан төрөл дээр шинэ ААН үүсгээд хөрөнгөө шилжүүлсэн байдаг.<br>-Хариуцагч эзэн БНХАУ-ын иргэн Ковид19 цар тахлаас өмнө нутаг буцсан.<br>-Битүүмжлэх эд хөрөнгө үгүй болохоор шийдвэр гүйцэтгэл удааширч байна гэж байлаа. | | |
| ХОЁР: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ | | | | | | | |
| 1. | 2.1 Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх | 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргүүлсэн байна. | | | Үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэр, тайлан, биелэлтийг холбогдох газар нэгжүүдэд цаг хугацаанд нь хүргүүлж байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 100% |
| 2. | 2.2 Ажил олгогч даатгуулагчдад Нийгмийн даатгалын тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан хууль, журам, | Зөвлөгөө мэдээлэл өгсөн ажил олгогчийн тоо | | 112 | Хүнс, хөдөө аж ахуйн газрын "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох төсөл хэрэгжүүлж эхэлж байгаатай холбогдуулан Дорнод аймгийн харъяат | 2025.01.01<br>2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүрэм заврын талаар зөвлөгөө өгч, нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэх; | | | | жижиг дунд бизнес эрхлэгч 66 иргэд аж ахуйн нэгжийн төлөөллөгчдөд, гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан сургалтад 46 аж ахуйн нэгжийн төөлөөлөгч нарт тус тус нийгмийн даатгалын хуулийн шинэчлэсэн найруулага сэдвээр сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна. | | |
| 3. | 2.3 Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн даатгуулагчийн төрөл, нийгмийн даатгалын тайлан, шимтгэл төлөлттэй холбоотой албан хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, | Шийдвэрлэл-тийн хувь | | 0 хувь | Хагас жилийн байдлаар ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн даатгуулагчийн цалин, төрөл засуулах нийгмийн даатгалын тайлан, шимтгэл төлөлттэй холбоотой хүсэлт ирээгүй байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 0% |
| 4. | 2.4 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, хуулийн өөрчлөлт, дагаж мөрдөх журам болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан боловсруулж илгээдэг portal.ndaaatgal.mn веб програмд гарсан өөрчлөлтүүдийг ажил олгогч даатгуулагчдад сурталчилан ажиллах | Зөвлөгөө мэдээлэл өгсөн ажил олгогчийн тоо | | | Нийгмийн даатгалын шимтгэлийн шинэ систем portal.ndaatgal.mn дээр гар буй өөрчлөлтүүдийн талаар заавар зөвлөгөөг биечлэн өгч ажиллсан байна. Мөн шинээр бүртгүүлж байгаа болон шинээр ажилд орж байгаа нягтлан бодогч нарт portal.ndaatgal.mn дээр тайлан хэрхэн шивж баталгаажуулах, даатгуулагчийн төрөл алдаа гаргахгүй байхын тул ажилтан бүртгэх, ажилтны мэдээлэл өөрчлөх, шимтгэлийн тайлан шивэх, шалгах, илгээх зөв бүртгэх талаар зөвлөж ажиллалаа. | 2025.01.01<br>2025.06.30 | 100% |
| 5. | 2.5 Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | 100 хувь | Хагас жилээр сумд 326 ажил олгогчтой тооцоо нийлж сар бүр хуулийн хугацаанд батлагдсан маягтын дагуу баталгаажуулан хүлээн авч ажилласан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн шинэ систем SICOS | 2025.01.01<br>2025.06.30 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | систем дээр бүргэлийн мэдээллийг шинэчилэн өөрчлөж ажиллаж байна. | |
| ГУРАВ. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮ | | | | | | |
| 1. | 3.1 ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, тушаал, шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хэрэгжүүлж ажилласан эсэх | | Тийм/үгүй | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг заасан хугацаанд нь боловсруулан батлуулж, төлөвлөгөөний биелэлт, тушаал, шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа. | 2 2 |
| 2. | 3.2 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Хэрэгжүүлж ажилласан эсэх | | Тийм/үгүй | Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн.<br>2024 онд авлага барагдуулах журмын дагуу хийгдсэн ажиллагааны баримтыг цэгцлэн ажилласан. Уг баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилж 4 ширхэг хадгаламжийн нэгж бүрдүүлэн хуулийн хугацаанд архивт хүлээлгэн өгч ажиллалаа. | 2 2 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.1 Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулахад хувь нэмэр оруулж байгаа байгууллагын албан хаагч ажилчдад талархалын бичиг хүргүүлэх | | | Нийгмийн даатгалын өр барагдуулах үйл ажиллагааг сайжруулах | Дорнод аймгийн цагдаагийн газрын эрэн сурвалжлах албаны 1 албан хаагч, НДЕГ арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээний дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг барагдуулах ажлаар дансны зарлагын гүйлгээх түр зогсоох мэдэглээр арилжааны банкуудын ахлах теллер нарын 6 ажилтанд хамтран ажилласан талаар талархалын бичиг хүргүүлэн ажилласан. Энэ нь тус газруудын ажилтан албан хаагч нарт урам зориг, урамжуулал болон хүрсэн | 2025.01.01 2025.06.30 | 100% |
| 1. | 1.2 Цахим хуудсан нийгмийн даатгалын шимтгэлийн portai.ndaaatgal.mn веб програмд гарсан өөрчлөлтүүдийг талаар санал бэлтгэж Нийгмийн даатгалын ерөнхий газарт явуулах. | | | Ажил олгогчдыг цахим шилжилтийг хялбаршуулах, өр авлагагүй байх, . | - Цахимаар илгээх, сар бүр цаасаар ирүүлж тулган батлгаажуулах. Жилд 2 удаа цаасаар ирүүлэхээр тухайн байгууллагын захирал удирдлагууд тайлагнасан байдлаа харахгүй ямар төлбөр, өр үүсээд байгаагаа хянахгүйн дээр бүүр өртэй байгаа мэдэхгүй байна.<br>- Ажил олгогчийн илгээсэн тайланг нийгмийн даатгалын байгуулллага хүлээн авч баталгаажуулан "Баталгаажсан" төлөвт шилжихэд "QR" кодтой байхаар<br>- Portal.ndaatagl.mn вэб программд ажил олгогч тайлан илгээхээр нэвтэрч ороход тайлан илгээх хугацаа болон | 2025.01.01 2025.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шимтгэлийн өрийн талаар сануулах масс мессеж өгөх,<br>- Portal.ndaatagl.mn вэб программд ажил олгогчид мэдээлэх,<br>- Ажил олгогчид мэдэгдэх хуудас хүлээн авсныг цахимаар баталгаажуулан илгээсний дараа portal.ndaatagl.mn тайлан нээх. Энэ нь нийгмийн даатгалын сангаас ажилтануудад тэтгэвэр, тэтгэмж олгохгүй (эрх үүсэхгүй) байгааг мэдэх<br>- Арилжааны банк дах зарлагын гүйлгээг мэдэгдлийн дагуу хааж, зөвшөөрлийн дагуу нээж байгаа ч Татварын байгууллагад эхлэж шилжүүлээд байгааг анхаарах<br>- Өр төлбөр төлөх нарийвчилсан тэмдэглэл, гэрээг 3-6 сар түүнээс доош байх. Өр төлбөр төлөх нарийвчилсан тэмдэглэл, гэрээг portal.ndaatagl.mn вэбд цахимаар хийгддэг болгох.<br>- SICOS програмаас Монгол банкинд цахимаар хүргүүлдэг байх | | |
| 2. | 1.3 Тэтгэврийн тайлантай хобоотой | | | | 2 дугаар сард Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга И.Төгсбаярын хуваарилсан 2024 оны тэтгэврийн тайланд хаалтыг 4-12 сарын гар олголтыг жагсаалтын дагуу авч тэтгэврийн программд олголтын хуваарь болон олголт үүсгэх, олголтыг шалгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 100% |
| | 1.4 Тэтгэврийн тайлан гаргахтай холбогдуулан алдаатай ирүүлсэн тайлан шивэх | | | | 4 дүгээр сард алтаатай тэтгэврийн тайлангийн хаалтыг хийх гэж 6 дугаар сарын 6 удаагийн гар олголтыг түүж ажиллалаа. Энэ ажлаар 6 удаагийн 662 | 2025.01.01<br>2025.06.30 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэтгэвэр авагчийн олголтыг Тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга И.Төгсбаяраар хянуулан хаалтыг хийсэн. | |
| | | | | | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Э д х |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | |
| 1. | 1.1 Үндэсний монгол бичгийн мэдлэг чадвараа сайжруулах | Ур чадварыг ахиулсан байх, | | Мэдлэг, чадвар дээшилсэн байна | Монгол Улсын Их хурлаас 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Монгол хэлний тухай хуулийг баталж 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдөхөөр заасан. Монгол бичгийн хичээлийг судлан суралцаж байна. | 20 20 |
| | 1.2 Манлайлал, ур чадварын сургалтад хамрагдах | Ур чадварыг ахиулсан байх, | | Мэдлэг, чадвар дээшилсэн байна | Төрийн өмчин бодлого зохицуулалтийн хорооноос зохион байгуулсан "Өмч хамгаалах зөвлөлийн өмчийн бүртэл хийх" талаарх сураглтад хамрагдсан. Цаашид НДЕГ-аас зохион байгуулсан авлагын менежмент, хэрэгжүүлэх талаар сургалт авах хүсэлтэй байна. | 20: 20: |
| 2. | 1.3 Нягтлан бодогчийн мэргэжлийн сургалтад хамрагдах | Мэргэжил ур чадвараа ахиулсан байх | | Онлайн сургалтанд сууж мэргэшсэн байна. | Нягтлан бодох бүртгэлийн талаарх өөрийн албан хэрэгцээн ашиглаж байгаа програмд ажиллаж байна. | 20: 20: |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| ХАМРАЛТ, ОРЛОГО ШИМТГЭЛИЙН ӨР ХАРИУЦСАН БАЙЦААГЧ<br>*( Албан тушаал )* | Т.ТҮВШИНБААТАР / ................................ /<br>*( Нэр, гарын үсэг )* | 2025<br>*( Оı* |